



МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2015 оны 11 сарын 25 өдөр

Дугаар 394

Улаанбаатар хот

“Монкорд” ХЗХ-ны хадгаламж, зээлийн үйл  
ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг  
сунгах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.5, Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 60 дугаар тогтоолоор батлагдсан “Хадгаламж зээлийн хоршооны зохицуулалтын журам”-ын 9.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Монкорд” ХЗХ-ын хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 2015 оны 6 дугаар сарын 20-ны өдрөөс эхлэн 3 жилийн хугацаагаар сунгасугай.

2. Тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хавсралтанд холбогдох тэмдэглэгээг хийлгэж, хувийг 4 дүгээр улиралд багтаан Хороонд ирүүлэхийг “Монкорд” ХЗХ /М.Рита/-нд үүрэг болгосугай.

3. Тогтоолыг олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /П.Алтан-Од/-т, холбогдох өөрчлөлтийг Хорооны нэгдсэн бүртгэлд бүртгэхийг Бүртгэл, зөвшөөрлийн газар /Э.Мөнхбаяр/-т, үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажиллахыг Хяналт шалгалтын газар /Б.Оюунцацрал/-т тус тус даалгасугай.

ДАРГА



З.НАРАНТУЯА

001048